




ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Эмэгтэйчүүдийн зөвлөл /цаашид зөвлөл гэх/-ийн зорилго нь орон тооны бус сайн дурын үндсэн дээр зохион байгуулагдан ҮБХИС-ийг хөгжүүлэх бодлого, стратегийн зорилгод хүрэх зорилтыг хэрэгжүүлэхэд болон удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд эмэгтэй ажилтан, албан хаагчдын санал, санаачилгыг тусгах, тэдний нийгмийн хамгааллыг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зэрэг эмэгтэйчүүдийн нийтлэг эрх ашгийг хамгаалахад оршино.

1.2 Зөвлөл нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын хуулиуд, “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм”, “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн хөдөлмөрийн дотоод журам” болон энэхүү журамд нийцүүлэн үйл ажиллагаа явуулна.

1.3 ҮБХИС-тай үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байгаа бүх эмэгтэйчүүд нь “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-ийн гишүүн байна.

ХОЁР. ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЗАРЧИМ, ЧИГЛЭЛ

2.1 Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь

2.1.1 бүх түвшний оролцоог хангах;

2.1.2 хууль дээдлэх;

2.1.3 ил тод, хүртээмжтэй байх;

2.1.4 зөвшилцөлд тулгуурлан ажиллах;

2.1.5 тэгш байдлыг хангах;

2.1.6 үр нөлөөтэй ашигтай байх;

2.1.7 хариуцлагатай байх зарчмуудад тулгуурлана.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд нь:

2.2.1. ҮБХИС-ийн хөгжил, дэвшилд эмэгтэйчүүдийн санал, санаачилга, оролцоог нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагаа явуулах

2.2.2 ҮБХИС-ийн эмэгтэй ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.2.3. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил, уран бүтээл, шинэ санааны төслийн ажлыг дэмжих;

2.2.4. Ажлын байран дээрээ хөгжих боломжийг нэмэгдүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжсэн сургалт семинар, хөтөлбөр, үйл ажиллагаа зохион байгуулах;

2.2.5. Гадаад болон дотоодын төсөл хөтөлбөр, сургалт семинарт хамрагдах боломжийг бүрдүүлж, эмэгтэйчүүдийг чадавхжуулах;

2.2.6. Офицер, ахлагч эмэгтэйчүүдийн, гэрээт ажилтан эмэгтэйчүүдийн, багш, ажилтан, эмэгтэйчүүдийн, эмэгтэй суралцагчдын гэх мэт төрөл мэргэжлийн баг, сонирхлын салбар зөвлөл, клуб ажиллуулах; (“Уран шаглаа” оёдолчин эмэгтэйчүүдийн клуб, Илтгэл мэтгэлцээний клуб, төслийн баг г.м)

2.2.7. Эмэгтэйчүүдийн манлайллын чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагаа зохион байгуулах;

2.2.8. Эмэгтэй ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхтэй холбоотой соёл урлаг, спортын уралдаан, тэмцээн олон нийтийн идэвхийг өрнүүлэх арга хэмжээ зохион байгуулах;

2.2.9. ҮБХИС-ийн засаглалын тогтолцоо, шийдвэр гаргах түвшинд жендерийн тэнцвэртэй байдлыг хангах;

2.2.10 Эмэгтэй ажилтан, албан хаагчдын эрхийг хамгаалах, жендерийн тэгш байдлыг хангуулахад хамтарч ажиллах

ГУРАВ. ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Зөвлөл нь хамтын удирдлага бүхий ардчилсан зарчмын үндсэн дээр дараах байдлаар зохион байгуулагдан ажиллана.

3.2 Зөвлөлийн үйл ажиллагааг нийт гишүүдийн төлөөллөөс бүрдсэн "Бүх гишүүдийн хурал"-аас батлан явуулна.

3.3 Бүх гишүүдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.3.1. Зөвлөлийн дүрмийг хэлэлцэж батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах;

3.3.2. Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож батлах, үйл ажиллагааны хөтөлбөр, тайланг хэлэлцэн батлах;

3.3.5. Удирдах зөвлөлөөс оруулсан бусад асуудлыг хэлэлцэн батлах;

3.4 Бүх гишүүдийн хурлын ээлжит хурлыг жилд 1 удаа хуралдуулна. Бүх гишүүдийн хурал хуралдах хугацааг гишүүдэд 7-оос доошгүй хоногийн өмнө зарлана. Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж болно.

3.5 Бүх гишүүдийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэрээр гарах бөгөөд хурлын үйл ажиллагааны явцад тэмдэглэл хөтөлнө. Бүх гишүүдийн хуралд оролцсон гишүүдийн ердийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

3.6 Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг Удирдах зөвлөл явуулна. Удирдах зөвлөл 7-9 гишүүнээс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 жил байна.

3.7 Удирдах Зөвлөлийн гишүүд аливаа асуудлыг шийдвэрлэхэд тэгш эрхтэй байна.

3.8 Удирдах зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

3.8.1. Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, нөхөн сонгохоор бүх гишүүдийн хуралд оруулах;

3.8.2 Зөвлөлийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулах;

3.8.3 Зөвлөлийн жилийн болон улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан бүх гишүүдийн хурлаар батлуулах;

3.8.4. ҮБХИС-ийн удирдлагад журмын үндсэн чиг үүрэгт хамааралтай асуудал тавьж шийдвэрлүүлэх;

3.8.5 Гишүүдийн сарын хураамжийн хэмжээг тогтоон бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

3.8.6. Зөвлөлийн гишүүнийг төрийн болон бусад байгууллагын шагнал, урамшуулалд шагнуулахаар тодорхойлж, холбогдох байгууллагад санал оруулах;

3.8.7 Удирдах зөвлөл хурлын дэгээ өөрсдөө тогтоох;

3.8.8 Удирдах зөвлөл ажлаа бүх гишүүдийн хуралд тайлагнана. Тайланг ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө урьдчилан тараасан байна;

3.9 Зөвлөл нь ҮБХИС-ийн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдэд офицер, ахлагч эмэгтэйчүүдийн, гэрээт ажилтан эмэгтэйчүүдийн, эмэгтэй ажилтнууд, багш эмэгтэйчүүдийн, эмэгтэй суралцагчдын гэсэн салбар зөвлөлүүдтэй байж болно.

3.10 Салбар зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:

3.10.1. Зөвлөлийн журмыг хүлээн зөвшөөрч үйл ажиллагаанд тэгш эрхтэйгээр оролцох;

3.10.2. Салбар зөвлөлийн гишүүн, дарга нь удирдах зөвлөлд сонгох, сонгогдох;

3.10.3. Салбар зөвлөл нь тодорхой асуудлаар санал боловсруулж Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

3.11. Салбар зөвлөлийн үүрэг:

3.11.1. Зөвлөлийн ажиллах журам, Удирдах Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.11.2. Эмэгтэйчүүдийн асуудлаар холбогдох судалгаа явуулж зөвлөлийн удирдлага, зохих шатны байгууллагад санал дэвшүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

3.11.3. Зөвлөлийн өмнөөс хариуцаж буй үндсэн болон төслийн хөрөнгө, хандив, тусламжийн талаар бүх гишүүдийн хурал, Удирдах Зөвлөлд тайлагнаж, хариуцлага хүлээх;

3.12. ҮБХИС-ийн Эмэгтэйчүүдийн Зөвлөлийн гишүүн дараах эрх эдэлнэ:

3.12.1 бүх гишүүдийн хуралд төлөөлөгчөөр сонгогдох;

3.12.2 зөвлөлийн бүх шатны байгууллагад сонгох, сонгогдох;

3.12.3 гишүүнээс гарах буюу дахин элсэх;

3.12.4 зөвлөлийн гишүүдийн хураамжаас бүрдсэн хамтын сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

3.13. зөвлөлийн гишүүн дараах үүрэг хүлээнэ.

3.13.1. зөвлөлийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох замаар сургуулийн хөгжил, дэвшилд хувь нэмрээ оруулах;

3.13.2. зөвлөлийн бүх шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх;

3.13.3. гишүүний хураамжаа тогтоосон хугацаанд төлөх;

ДӨРӨВ. САНХҮҮЖИЛТ

4.1. Зөвлөл нь өөрийн үйл ажиллагааг гишүүдийн хураамжаар хамтын сан бүрдүүлэн санхүүжүүлнэ.

4.2 Гишүүний сарын хураамжийн хэмжээг зөвлөлийн хурлаар олонхын саналаар шийдвэрлэнэ.

4.3 Гишүүдийн хураамжийн зарцуулалтын тайланг удирдах зөвлөл улирал бүрээр хариуцан гаргаж, бүх гишүүдийн хуралд тайлагнана.

ТАВ. ХАРИУЦЛАГА

5.1. Зөвлөлийн Удирдах зөвлөл, гишүүдийн хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, байгууллагад учирсан хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг ҮБХИС хүлээхгүй.

5.2. Зөвлөлийн Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүд, гишүүдийн хууль бус үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ